



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022. 04. 13 № 15

Асуулт тавих тухай

2013 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан ХХ.1.60 хуулийн дугаартай Гэр хорооллын инженерийн шугам, сүлжээ /Хөвсгөл, Мөрөн/ төсөл, арга хэмжээний ажлын даалгаварт Мөрөн сумын 6, 7, 13-р хороодыг цэвэр усны шугамд холбох ажил багтсан.

Тухайн онд танай яамнаас түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр тендер зарлаж гүйцэтгэгчээр “Монгол дайван” ХХК шалгаран, ажлын зураг төслийг “Түвшин жин” ХХК-аар хийлгэсэн байдаг. Гэвч тухайн компаниуд технологийн шийдлээ алдаатай гаргасны улмаас цэвэр усны шугамыг иргэд ашиглах боломжгүй байдал үүсч, ажил удаашран нэмэлт хөрөнгө оруулалтаар 7, 13-р хороодын цэвэр, бохир усны шугамууд ашиглалтад орсон. Харин 6-р хорооны шугам сүлжээний ажил өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн уг шугам сүлжээг хэвийн горимоор ажиллуулах талаар танай яам, аймгийн удирдлагууд болон холбогдох байгууллагуудын төлөөлөл гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай удаа дараа уулзаж, албан хүсэлт өгч ажилласан боловч үр дүнд хүрээгүй бөгөөд улсын комисс шугамыг хүлээн авсан ч одоог хүртэл “Хөвсгөл ус суваг” ХХК албан ёсоор хүлээн аваагүй гэсэн тайлбар өгч байна.

Уг ажлын ТЭЗҮ-ийг танай яамны даалгавраар боловсруулж, барилга угсралтын ажил хийгдсэн бөгөөд тухайн үед улсын комисс хүлээж авсан болно.

Миний бие уг асуудлаар 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр УИХ-03/11540 дугаар албан бичгээр Танд хандаж, шаардлагатай арга хэмжээг авах талаар санал боловсруулж танилцуулахыг хүссэн ч албан ёсны хариу одоог хүртэл ирүүлээгүй байна.

Иймд миний бие Улсын Их Хурлын гишүүний хувьд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 12 дугаар зүйлийн 12.1-д тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6-р хороонд технологийн буруу шийдлээр хийгдсэн гэх шугам сүлжээний ажлыг ашиглалтад оруулах талаар захиалагчийн хувьд ямар арга хэмжээ авч ажилласан, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар;

2. Тухайн шугам сүлжээний ажлыг ашиглалтад оруулахад шаардлагатай арга хэмжээг авах тухай санал боловсруулж танилцуулахыг хүссэн миний 2021 оны 11

2022000035

дүгээр сарын 23-ны өдрийн УИХ-03/11540 дугаар албан бичгийн хариуг ямар шалтгаанаар хуулийн хугацаанд ирүүлээгүй эсэх талаар;


3. Улсын төсвийн ихээхэн хэмжээтэй хөрөнгө оруулалтаар хийгдсэн, улсын комисс хүлээн авсан энэхүү ажлыг ашиглахгүй, ашиглалтын горим алдагдуулж, урсгал засвар хийхгүй хаяж, тоногдсон явдалд хэн хариуцлага хүлээх, яагаад эзэнгүйдүүлж орхисон талаар;

4. Энэхүү хөрөнгө оруулалтын ашиглалтын асуудлаар миний бие танай яаманд хэд хэдэн удаа хандсан бөгөөд энэ талаар ямар арга хэмжээ авч ажилласан талаар;

5. Улсын төсвийн хөрөнгө оруулалт ашиглагдахгүй, шамшигдаж, тоногдох байдал бүрдсэнд ямар байгууллага хариуцлага хүлээх, энэ талаар танай яамнаас ямар арга хэмжээнүүд авч ажилласан талаар зэрэг болно.

Төрийн байгууллагуудын албан бичгийн харилцааг зохицуулсан хуулийн хугацаа хэтэрсэн нь хуулийг үл хүндэтгэх нөхцөл байдал үүсээд байгааг анхаарч асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.ДАВААСҮРЭН

2022000035